

# НИЙТИЙН БИЕЙН ТАМИРЫН ТАЛБАЙН БАРИЛГЫН АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ



ЗАСАГ ДАРГА **НЯМРАГЧАА**

## III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

### **Завхан аймгийн Асгат сум. Нийтийн биеийн тамирын талбайн барилгын ажил**

- А. Ажил гүйцэтгэх хугацааны график хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоог тодорхой гаргаж ирүүлнэ.
- Б. Барилгын норм, норматив ба дүрэм, стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх
- В. Үнийн саналд зураг төсвийн үнийг захиалагчийн хяналтын зардлыг, талбайн угсралтын ажлын төсөвт өртгийн дүнгийн 2%-иар зохиогчын хяналтын зардлыг захиалагчийн хяналтын зардлыг 50%-иар тооцож тусгаж ирүүлэх
- Г. Төсөв зохиохдоо Барилгын, хот байгуулалтын сайдын 2012 оны 181 тоот тушаалын дагуу нэмэгдэл зардал, төлөвлөгөөт ашиг, техник хяналт, нормчлолын сан% НӨАТ, магадлашгүй ажлын зардал, зэргийг тооцож барилгын төсөв зохиох дүрэм БНБД "Ү" 91-95-12/2020/-г мөрдлөг болгоно.
- Д. Үнийн дүнгийн тарифыг тооцон ирүүлэхдээ ажилбар тус бүрээр тооцож ирүүлнэ.
- Е. Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэх боловсруулах

#### **Өрөгт бүтцийн ажил**

Өрөгт бүтээцийн ажлыг зураг төсөвт завсны дагуу гүйцэтгэж БНБД 51-02-05-г баримтлана. /Блокоор өрөх/

Явган хүний болон гүйлтийн замын суурийг 13-15 см зузаантай элс хайрга-цементл хольцоор хийж свитэр нягтаршуулан хийж гүйцэтгэх  
Барилгын ажлыг зориулалтын техник хэрэгсэл болон чадварлаг мэргэжлийн боловсон хүчнээр хийлгүүлэн гүйцэтгүүлнэ.

#### **Гадна, дотно цахилгааны болон бусад ажил**

Гадна ханыг цөмөнт болон шохойн гоёлоор сайн чанартай хийх

Гадна ханад сайн чанарын замаск түрхэх

Асарын гадна талын ханыг усан эмульсэн будгаар будах

Асарын дээрийг уян сайн чанарын карказ төмрөөр угсарч хийх

Бетонон суурьтай гадна ил тоноглох гэрлийн самбар хийх бөгөөд төсөвт завсан ажлыг чанартай хийж гүйцэтгэх. Аюулгүй ажиллагааг хангах

Зам талбайн ажил, бусад ажлыг төсөвт зааж өгсөний дагуу чанартай хийж гүйцэтгэх шаардлагатай. Тендрийн баримт бичигт ерөнхий план зураг, ажлын даалгавар, төсөв зэргийг оруулж өгсөн тул төсвийн дагуу чанартай хийж гүйцэтгэнэ. Төсөвт тусгасанаас өөр материал ашиглахгүй бөгөөд түүнтэй дүйцэхүүц төмөр угсармал, бетонон хольмог байж болно.

#### **Тендэрт шалгарсан гүйцэтгэгч нь:**

1. Барилга байгууламжийн ажлыг батлагдсан зураг, төсөв, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ. Хугацаа хоцорсон тохиолдолд алданги тооцно.
2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

3. Барилга байгууламжийн ажлыг эхлүүлэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор анхааруулга тэмдэг тэмдэглэгээг байршуулах, болон анхааруулга авч ажиллах
4. Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүн болон үнийн баримт зэргийг хавсаргана.
5. Гүйцэтгэсэн ажил тус бүрт акт бичиж, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байх
6. Барилга байгууламжийн ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгөх
7. Барилгын зураг төсөөт зааснаас өөр зөвөөр маягаар барих тохиолдолд захиалагч болон гүйцэтгэгч байгууллагатай харилцан ярилцаж зөвшилцөх
8. Хэрэв барилга байгууламж зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад бичгээр хүсэлтээ гаргаж ажлын 7 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зураг төсвийн дагуу гүйцэтгэнэ.
9. Гүйцэтгэгч нь барилгын ажлын ил, далд ажлын актыг баталгаажуулж, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг бүрэн биелүүлнэ.
10. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд барилгын ажлыг зогсоох хүртэл арга хэжээ авч ажиллана.
11. Монгол улсын барилгын тухай хуулийн дагуу хийж гүйцэтгэн заасан хугацаанд дуусгавар болсон тохиолдолд гүйцэтгэгч зураг төсөв зохиогч захиалагч болон ашиглагч тухайн барилга байгууламжид хамтарсан үзлэг хийж зөрчлийг арилгах талаар тэмдэглэл үйлдэх бөгөөд зөрчлийг арилгаснаар дуусгавар болгон барьсан барилга байгууламжид баталгаа гаргаж өгнө.

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

